**БНМАУ-ЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН ЯАМНЫ КОЛЛЕГИ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАМТАРСАН ХУРЛЫН**

# Т О Г Т О О Л .

1982 оны 3 дугаар сарын 1 ны өдөр — Дугаар 33/31 — Улаанбаатар хот

**ПАРТИЗАН, ХУВЬСГАЛТ ТЭМЦЛИЙН АХМАД ЗҮТГЭЛТЭН НАРЫГ ХҮНСНИЙ ЗҮЙЛЭЭР ҮЙЛЧЛЭХ ДЭЛГҮҮР БАЙГУУЛАХ ТУХАЙ**

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1980 оны 39-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор худалдаа бэлтгэлийн яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Хотын худалдаа удирдах газар /н.Пагдар/-т даалгах нь:

а/ардын хувьсгалын партизан, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн нарт хүнсний зарим нэрийн бараагаар захиалга авч үйлчлэх үүргийг Хүнсний барааны 17-р дэлгүүрт хариуцуулах.

б/үүнтэй холбогдуулан 17-р дэлгүүрт худалдаалж байгаа хүүхдийн хүнс тэжээлийг 73-р дэлгүүрт шилжүүлж, 73-р дэлгүүрийг "Хүүхдийн хүнс, тэжээлийн дэлгүүр" болгон өргөтгөн зохион байгуулах.

в/партизан, ахмад зүтгэлтэнд зориулсан 17-р дэлгүүрт тоног төхөөрөмж, телефон утас тавьж үйлчилгээнд шаардагдах арга хэмжээ авах.

г/БНМАУ-ын хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хороотой саналаа тохиролцооны үндсэн дээр тус дэлгүүрийн үйлчилгээний журмыг энэ оны 4-р сарын 1-ний дотор баталж мөрдүүлэх.

д/БНМАУ-ын ахмад зүтгэлтний хорооны тодорхойлолтыг үндэслэн биеийн эрүүл мэнд сайнгүй, харгалзан тэжээх үр хүүхэд, ах дүү төрөл садангүй зарим партизан, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн нарын захиалгыг 7 хоногт нэгээс доошгүй удаа авч барааг гэрт нь хүргэж өгөх үйлчилгээг зохион байгуулах.

ө/эорийн системийн орон тоо, цалингийн фондонд багтаан нэгийн орон тоог авч ажиллуулах.

2.Дэлгүүрт худалдах хүнсний зарим барааны нэр төрлийг хавсралтаар баталсугай.

3.Ахмад зүтгэлтний 17, хүүхдийн хүнс тэжээлийн 73-р дэлгүүрийг Улаанбаатар хотын фондод багтаан хүнсний импортын бараагаар сард хоёр удаа үйлчилж байхыг Бөөний худалдааны нэгдэл /н.Орсоо/, эх орны бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангаж байхыг Сүүний үйлдвэр /н.Магсаржав/, Талхны үйлдвэр /н.Ядамсүрэн/, Чихэр боовны үйлдвэр /н.Пүрэвжав/, Архи пивоны комбинат /н.Гантөмөр/, Ногооны комбинат /н.Идэш/, Хотын худалдаа удирдах газар /н.Шагдар/-т даалгасугай.

4.Партизан, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн зарим хүмүүсийн гэрээр захиалга авч, барааг хүргэж үйлчлэхэд зориулан Москвич 2 маркын машиныг Худалдааны 1-р конторын гэрээт машин дээр нэмж өгөхийг Хотын тээврийг удирдах газар /н.Сэрээтэр/-т даалгасугай.

5.17-р дэлгүүрт яаралтай телефон утас тавьж өгөхийг Телефон радио сүлжээний хороо /н.Бэгзэ/, 380 вольтын шугам оруулахыг Цахилгаан шугам сүлжээний газар /н.Дашзэвгээ/, тоног төхөөрөмж монтажилж өгөхийг Худалдааны тоног төхөөрөмжийн засвар зарлал, чимэглэлийн газар /н. .Наморай/-т даалгасугай.

7.Энэ тогтоолын биелэлтэнд байнга хяналт тавьж ажиллахыг Хотын худалдаа удирдах газар /н.Шагдар/-т даалгасугай.

БНМАУ-ын Худалдаа, бэлтгэлийн яамны сайд Ч.МОЛОМ

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны дарга С.МӨНХЖАРГАЛ

БНМАУ-ын Худалдаа бэлтгэлийн яамны
коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын
гүйцэтгэх захиргааны 1982 оны 38/21
тоот тогтоолын хавсралт.

ПАРТИЗАН, ХУВЬСГАЛТ ТЭМЦЭГЧИЙН АХМАД
ЗҮТГЭЛТЭН НАРТ ҮЙЛЧЛЭХ ХҮНСНИЙ
БАРААНЫ НЭР ТӨРӨЛ.

1. Хонины мах
2. Үхрийн мах
3. Сүү
4. Тараг, айраг
5. Цөцгий
6. Цөцгийн тос
7. Идээний тос
8. Төрөл бүрийн гурил
9. Арвайн гурил
10. Лаазалсан сүү
11. Өтгөрүүлсэн сүү
12. Махан консеров
13. Ногооны консеров
14. Жимсний консеров
15. Цагаан будаа
17. Шар будаа
18. Хуурай сүү
19. Загасны консеров
20. Хуурай жимс
21. Талх
22. Ботон
23. Элсэн чихэр
24. Нарийн боов
25. Төрөл бүрийн чихэр
26. Төрөл бүрийн печень
27. Шинэ жимс

ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН ЯАМ

УБ ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГАА